

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МЯНГАД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/43/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Гантулга Утас: 70432545 цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	8
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	16
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	17

## 1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МЯНГАД СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
ЭМЧ Ж.ЭНХЧУЛУУН ТАНАА

2021.02.25 № 4153  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эмчийн ёс зүй зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын Аудитын гол асуудал

Шатахуун зарцуулалтын тооцоог анхан шатны хүчин төгөлдөр баримтаар тооцоогүй, спидометрийн заалт баримтлаагүй жолоочийн тооцоог бодож албажуулаагүй, хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй о өртөгтэй их хэмжээний хөрөнгө тайланд тусгагдан олон жил болсон, эмийн нэр төрлийн тооллого хийж тооцоо бодоогүйгээс эм дутагдуулсан, жирэмслэлтээс хамгаалах эм тариаг мөнгөөр үнэлж зарцуулж байгаа талаар ард иргэдээс ирүүлж байгаа мэдээлэл нь үндэслэлтэй, эзэн холбогдогч тодорхойгүй насажсан авлага

021020669

барагдуулаагүй, цалингийн нэмэгдлийг тогтоол, журамд нийцүүлээгүй, үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Төрийн албаны тухай хуулийн 37.1.13-д "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын "1.5", "2.1", "3.2", "3.6", "3.7.3" дахь заалтууд, Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>55,853,258.69</u></b>	<b><u>39,944,597.03</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,160,463.78	3,067,619.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,442,732.78	1,787,412.18
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	717,731.00	1,280,207.00
3351	Байгууллагаас авах авлага	371,500.00	1,280,207.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	53,692,794.91	36,876,977.85
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,195,150.36	7,802,723.00
35130	Эм боох материал	13,195,150.36	7,802,723.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	40,497,644.55	29,074,254.85
35410	Бичиг хэргийн материал	1,449,390.00	1,027,300.00
35420	Аж ахуйн материал	33,004,154.49	23,127,894.85
35430	Сэлбэг хэрэгсэл	3,910,000.00	4,382,500.00
35440	Тулш, шатах тослох материал	437,000.00	180,000.00
35460	Хүнсний материал	1,697,100.06	356,560.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>467,281,989.06</u></b>	<b><u>442,378,843.71</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	467,281,989.06	442,378,843.71
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	457,300,189.06	432,397,043.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	392,736,940.00	392,736,940.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,453,919.44	-27,200,838.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,632,756.00	51,632,756.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,662,643.40	-31,312,337.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,557,203.27	93,751,103.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,928,028.12	-67,658,944.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,128,535.60	44,678,535.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,790,654.85	-24,310,170.54
39217	Ном	80,000.00	80,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,981,800.00	9,981,800.00
39301	Програм хангамж	525,000.00	525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-525,000.00	-525,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,981,800.00	9,981,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>523,135,247.75</u></b>	<b><u>482,323,440.74</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7,770,126.32</u></b>	<b><u>930,708.49</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,770,126.32	930,708.49
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,770,126.32	930,708.49
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	898,918.32	918,813.49
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	6,871,208.00	11,895.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,871,208.00	11,895.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>515,365,121.43</u></b>	<b><u>481,392,732.25</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	515,365,121.43	481,392,732.25

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	159,985,026.00	159,985,026.00
51101	Өмч: - төрийн	159,985,026.00	159,985,026.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-66,280,208.29</b>	<b>-100,252,597.47</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-71,465,108.55	-73,218,709.55
51220	Тайлант үеийн үр дүн	5,184,900.26	-27,033,887.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	421,660,303.72	421,660,303.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>523,135,247.75</b>	<b>482,323,440.74</b>

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>416,122,368.00</b>	<b>453,024,468.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,440,222.00</b>	<b>19,011,566.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	16,218,000.00	18,665,335.00
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>		18,665,335.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,218,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,218,000.00	18,665,335.00
<b>310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	361,165,700.00	358,389,552.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,165,700.00	358,389,552.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>44,982,546.00</b>	<b>73,193,433.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,699,600.00	361,165,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,100.00	17,061,565.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,100.00	17,061,565.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	19,430,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	19,430,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	24,059,646.00	36,701,268.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,059,646.00	36,701,268.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>410,937,467.74</b>	<b>480,058,355.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>410,937,467.74</b>	<b>480,058,355.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	410,937,467.74	476,782,207.92
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	257,533,560.00	298,575,971.00
210101	Үндсэн цалин	257,533,560.00	298,575,971.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,752,927.32	36,481,525.77

210201	Тэтгэврийн даатгал	33,752,927.32	36,481,525.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,099,300.00	18,718,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,478,000.00	1,416,868.00
210302	Түлш, халаалт	13,110,500.00	11,801,432.00
210303	Цэвэр, бохир ус	5,510,800.00	5,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,333,950.00	36,911,769.64
210401	Бичиг хэрэг	2,685,590.00	3,911,090.00
210402	Тээвэр, шатахуун	15,844,580.00	12,524,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	638,350.00	1,017,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	452,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	11,745,228.07
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,125,430.00	7,262,131.57
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,294,577.94	47,042,747.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,136,878.00	36,587,107.36
210502	Хоол, хүнс	6,157,699.94	10,455,640.06
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,000.00	25,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,000.00	25,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,142,900.00	709,400.00
210702	Дотоод албан томилолт	1,142,900.00	709,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,268,384.00	8,868,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,441,684.00	8,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	28,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	676,700.00	165,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30,476,868.48	29,449,194.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,361,570.00	2,740,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,115,298.48	26,708,544.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	3,276,148.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	2,776,148.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,776,148.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,184,900.26</b>	<b>-27,033,887.92</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,184,900.26</b>	<b>-27,033,887.92</b>

**2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	397,682,146.00	434,359,133.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,682,146.00	434,359,133.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	20,897,800.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,897,800.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	352,699,600.00	361,165,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,100.00	17,061,565.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,100.00	17,061,565.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	19,430,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	19,430,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,059,646.00	36,701,268.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,059,646.00	36,701,268.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	397,682,146.00	434,359,133.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,682,146.00	434,359,133.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,682,146.00	431,429,216.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,430,000.00	296,434,231.00
210101	Үндсэн цалин	177,594,100.00	200,251,130.70
210102	Нэмэгдэл	60,396,900.00	70,993,100.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	6,336,000.00
210104	Урамшуулал	14,103,000.00	18,854,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,303,800.00	38,686,069.00
210201	Тэтгэврийн даатгал	21,966,600.00	27,120,969.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,584,300.00	2,891,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,067,600.00	2,313,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	516,700.00	578,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,168,600.00	5,782,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,382,000.00	18,281,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,868,000.00	1,742,600.00
210302	Түлш, халаалт	12,014,000.00	11,038,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,000.00	5,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,738,890.00	19,224,220.00
210401	Бичиг хэрэг	2,550,020.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,574,890.00	12,524,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,314,200.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,299,780.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	34,935,372.00	40,592,365.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,883,847.00	30,092,365.00
210502	Хоол, хүнс	7,099,625.00	9,000,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	951,900.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,515,800.00	2,763,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	1,666,700.00
210604	Урсгал засвар	1,515,800.00	1,096,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,150,000.00	709,400.00
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	709,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,300,684.00	8,868,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,441,684.00	8,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	179,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	28,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	680,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,925,600.00	5,524,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,925,600.00	5,524,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	3,276,148.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,776,148.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,776,148.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,003,226.00	146,022,626.00	-66,451,818.22	229,574,033.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>150,003,226.00</b>	<b>146,022,626.00</b>	<b>-66,451,818.22</b>	229,574,033.78
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,152,115.33	-9,152,115.33
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>159,985,026.00</b>	<b>421,660,303.72</b>	<b>-66,280,208.29</b>	515,365,121.43
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>159,985,026.00</b>	<b>421,660,303.72</b>	<b>-66,280,208.29</b>	515,365,121.43

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-6,938,501.26	-6,938,501.26
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>159,985,026.00</b>	<b>421,660,303.72</b>	<b>-73,218,709.55</b>	508,426,620.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,033,887.92	-27,033,887.92
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>159,985,026.00</b>	<b>421,660,303.72</b>	<b>-100,252,597.00</b>	481,392,732.25

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	412,226,300.00	414,521,420.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	412,226,300.00	414,521,420.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	411,726,300.00	414,021,420
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	291,141,300.00	289,128,500.30
210101	Үндсэн цалин	192,945,400.00	192,945,400.00
210102	Нэмэгдэл	73,005,900.00	70,993,100.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000.00	6,336,000.00
210104	Урамшуулал	18,854,000.00	18,854,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,304,000.00	39,032,300.00
210201	Тэтгэврийн даатгал	27,738,900.00	27,467,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,891,200.00	2,891,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,313,000.00	2,891,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	578,300.00	578,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,782,600.00	5,782,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,802,500.00	19,382,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,263,800.00	1,742,600.00
210302	Түлш, халаалт	11,038,700.00	11,038,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,000.00	5,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,522,600.00	19,218,520.00
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,822,600.00	12,518,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	30,640,000.00	30,640,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,140,000.00	20,140,000.00
210502	Хоол, хүнс	9,000,000.00	9,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,928,100.00	2,763,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00	1,613,900.00
210604	Урсгал засвар	1,228,100.00	1,149,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	565,400.00	565,400.00
210702	Дотоод албан томилолт	565,400.00	565,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,868,000.00	8,868,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,200,000.00	8,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	1,500,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	165,000.00	518,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	5,524,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,524,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>500,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг		500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	417,902,000.00	414,521,420.00
<b>310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	361,165,700.00	<b>358,389,552.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,165,700.00	358,389,552.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>19,430,600.00</b>
132007	Орон нутгийн төсвөөс		19,430,600.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	36,705,700.00	36,701,268.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36,705,700.00	3,6701,238.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	7	7

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,820,523.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,820,523.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	15,820,523.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,959,500.00
210201	Тэтгэврийн даатгал	6,959,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,711,323.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,711,323.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	144,000.00
210702	Дотоод албан томилолт	144,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	15820523.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,820,523.00

131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	15,820,523.00
--------	---	---------------

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч эмч Ж.Энхчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын үр дүнгийн урамшуулал, цалингийн нэмэгдэл, И баримтаар баталгаажуулж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаар хорио цээр тогтож, ТШЗ-дын тайлангийн хугацаа хойшлогдож, ачаалал нэмэгдсэнтэй холбоотойгоор 2021 оны 3 дугаар сарын 2-ноос 2021 оны 03 дугаар сарын 14-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мянгад сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сумынхаа ард иргэдэд мэргэжлийн өндөр түвшинд тэгш хүртээмжтэй, шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлнэ” гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мянгад сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 410873.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4108.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 480058.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4800.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40811.8 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	2160.4	3067.6	907.2
БАРАА МАТЕРИАЛ	53692.8	36876.9	(16815.9)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	467281.9	442378.8	(24903.1)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>523135.2</b>	<b>482323.4</b>	<b>(40811.8)</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7770.1	930.7	(6839.4)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	515365.1	481392.7	(33972.4)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>523135.2</b>	<b>482323.4</b>	<b>(40811.8)</b>

Оны эхэнд 2160.4 мянган төгрөгийн авлага байснаас 717.7 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд нэмэлт дансанд 1241.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагад бүртгэснээр 907.2 мянган төгрөгөөр авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36876.9 мянган төгрөг болж 16815.9 мянган төгрөгөөр буурсан нь эмийн үлдэгдэл буурсан, аж ахуйн материалууд акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 467281.9 мянган төгрөг, оны эцэст 442378.8 мянган төгрөг болж буурсан байна.

Энэ нь тайлант онд 7193.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1550.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгдэж, өмнөх оны элэгдлээс 6938.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 37023.2 мянган төгрөг буюу 9.3 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 44732.7 мянган төгрөг буюу 15.3 хувь, нормативд зардал 5657.0 мянган төгрөг буюу 16.1 хувиар өссөн, тогтмол зардал 1100.7 мянган төгрөг буюу 5.6 хувь, хангамж бараа материалын зардал 2514.6 мянган төгрөг буюу 11.5 хувь, эд хогшил урсгал засварын зардал нь 2752.6 мянган төгрөг буюу 49.9 хувь, томилолтын зардал 38.3 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 7432.6 мянган төгрөг буюу 45.5 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 2401.4 мянган төгрөг буюу 30.2 хувиар буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 413427.0 мянган төгрөгөөр нийт зардлыг 413427.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлан онд улсын төсвөөс 361165.7 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 19430.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 36701.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 417297.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2776.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### 3.6. Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дутагдаж байгаа зардалд 17061.5 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Эрүүл мэндийн газраас 15820.5 мянган төгрөгийг авч нийгмийн даатгалын шимтгэлд 6959.5 мянган төгрөг, сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн зардалд 23.4 мянган төгрөг, томилолтын зардал 144.0 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 8693.6 мянган төгрөг зарцуулж 1241.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроож 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 16 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 24946.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1001.6	2	1001.6	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	23945.2	2	23945.2	-	-	-
Нийт дүн	4	24946.8	4	24946.8	-	-	-

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 90580.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1598.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 87069.6 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага, 929.8 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах тухай 1 албан шаардлага, 982.5 мянган төгрөгийн зөрчилд алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 90580.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 1598.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 87999.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1.Эмнэлгийн албаны машины жолоочийн тооцоо бодож албажуулаагүй, машины спидометрийн заалтыг баримтлаагүй, иж бүрдэл дутуу замын хуудсаар тооцоо хийж шатахуун зарлагадсан 358.3 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтууд, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Эмийн нэр төрлийн тооллого хийгээгүй, тооцоо бодож баталгаажуулаагүйтэй холбоотой тайлангийн мөнгөн хөрөнгийн эмийн зарлага, эм зүйчийн бодит баримтаар гарсан эмийн зарлага зөрүүтэй үлдэгдэл бодитой боловч эмийн зарлага дутсан 1240.0 мянган төгрөг нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтууд, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 126 нэр төрлийн үндсэн хөрөнгө дахин үнэлж бүртгэлцүүлээгүй, эдгээрээс 18 нэр төрлийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн, тээвэр шатахууны зардлаас алсын дуудлагын бүртгэлд бүртгэгдээгүй, анхан шатны бүрдэл болоогүй баримтаар шатахуун зарлагадсан, хувь хүмүүстэй холбоотой эзэн холбогдогч нь тодорхойгүй олон жил болсон насажсан авлагатай зэрэг зөрчил нь Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв

байх”, ЗГ-ын 2011 оны 311 тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтууд, Аудитын олон улсын стандартын -300, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Жирэмслэлтээс хамгаалах эм тариаг эм зүйчээс эх баригчид бөөнөөр нь зарлагадаж олгосон, эх баригч нь эмэгтэйчүүд болон эхчүүдэд уг тариаг хийх, эм олгохдоо мөнгөөр үнэлж зарцуулж байгаа талаар ард иргэдээс ирүүлж байгаа мэдээлэл нь үндэслэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20-р зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төрийн албаны тухай хуулийн 37.1.13-д “албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах”, ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын “1.5”, “2.1”, “3.2”, “3.6”, “3.7.3” дахь заалтууд, Аудитын олон улсын стандартын -300, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага хүргүүлэв.

**3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД ҮГҮЙ.**

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

1.1.1 Илрүүлэлт: Цалингийн нэмэгдлийг холбогдох тогтоол, журамд нийцүүлээгүй, үр дүнгийн урамшууллыг ажилтнуудын ажлыг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах”, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын “З” дахь заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, ЗГ-ын 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, эрхлэгч эмч эмчлэгч эмчийн ажил хавсарсны нэмэгдлийг олгохгүй байх, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн биелэлтээ хэрхэн биелүүлж байгааг нэг бүрчлэн дүгнэж байж олгох.

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### **1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Тайлант онд борлуулалт болон худалдан авалтаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх

тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Мянгад сумын Эрүүл мэндийн төв	Аудитын код:
2021			ХОА-2021/43/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мянгад		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эмнэлгийн албаны машины жолоочийн тооцоо бодоогүй, иж бүрдэл дутуу замын хуудсаар тооцоо хийж шатахуун зарлагдсан	358.3	Төлбөрийн акт		
2	Эмийн нэр төрлийн тооллого хийгээгүй, тооцоо бодож баталгаажуулаагүйтэй холбоотой эмийн зарлага дутагдуулсан	1240.0	Төлбөрийн акт		
3	Хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглагдах боломжгүй хөрөнгө тайланд бүртгэлтэй олон жил болсон, тээвэр шатахууны зардлаас алсын дуудлагын бүртгэлд бүртгэгдээгүй, анхан шатны бүрдэл болоогүй баримтаар шатахуун зарлагдсан, хувь хүмүүстэй холбоотой эзэн холбогдогч нь тодорхойгүй олон жил болсон насажсан авлага барагдаагүй	87069.6	Албан шаардлага	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Ч.Энхчулуун Д.Баярмаа
5	Жирэмслэлтээс хамгаалах эм эмэгтэйчүүд болон эхчүүдэд уг тариаг хийх, эм олгохдоо мөнгөөр үнэлж зарцуулж байгаа талаар ард иргэдээс ирүүлж байгаа мэдээлэл нь үндэслэлтэй байна.	929.8	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Эрхлэгч эмч, нягтлан бодогч	Ч.Энхчулуун Д.Баярмаа
6	Цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг ажилтнуудын ажлыг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон.	982.5	Зөвлөмж		
7	Борлуулалт болон худалдан авалтаа И баримтаар баталгаажуулаагүй	0	Зөвлөмж		
<b>Дүн</b>		90580.2			

## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР